

**НИСЭХ БУУДЛЫН ХАТУУ ХУЧИЛТТАЙ ЭЛЕМЕНТҮҮДИЙН ДААЦЫГ  
ТОДОРХОЙЛОХОД ШААРДЛАГАТАЙ ГЕОТЕХНИКИЙН СУДАЛГААНЫ АЖЛЫН  
ТЕХНИКИЙН ДААЛГАВАР**

Зориулалт	Нисэх буудлын аэродромын хучилттай элементүүдийн даацыг тодорхойлоход шаардлагатай хөрсний инженер геологийн судалгаа хийх, хиймэл хучилтын техникийн үзүүлэлтийг тодорхойлж, геотехникийн судалгааны тайлан гаргах
Нийтлэг үндэслэл	Зам, тээврийн хөгжлийн яамны харьяа Нислэг техникийн осол, зөрчлийг шинжлэн шалгах албаны Зөвлөмж:20091027, 20091028, “Аэродромд тавигдах шаардлагууд”-ын 2.2.3.4, 2.2.3.5, 2.2.3.6 болон холбогдох дүгнэлт, шаардлагуудыг хэрэгжүүлэх
Ажлын нэр	Нисэх буудлын хатуу хучилттай элементүүдийн даацыг тодорхойлоход шаардлагатай геотехникийн судалгааны ажил
Ажлын талбай	Увс, Баян-Өлгий, Говь-Алтай, Мөрөн, Өмнөговь, Баянхонгор аймгуудын нисэх буудлын талбай.
Ажлын бүрдэл	<p>Судалгааны ажил нь дараах шаардлага, бүрдлийг хангасан байна. Үүнд:</p> <ol style="list-style-type: none"> <li>1. Хөрсний инженер геологийн судалгаа: <ul style="list-style-type: none"> <li>– Лабораторийн судалгаа, шинжилгээний үр дүн нь Монгол улсын Итгэмжлэгдсэн лабораториор баталгаажуулж, үр дүнг хавсаргасан байх</li> <li>– Судалгаа шинжилгээ хийх өөрийн болон хамтран ажилладаг лабораторитой байх</li> <li>– Судалгааны аргачлалыг тодорхой бичих ба бүс нутгийн онцлогоос хамааруулж 3 метрээс багагүй гүнд судалгааны өрөмдлөгийг хийх</li> <li>– Тухайн аэродромын байрлаж буй газар нутгийн гадаргын хэв шинж ба физик геологийн үзэгдэл, үйл явцын судалгаа хийх</li> <li>– Гидрогеологийн нөхцөлийн судалгаа хийх</li> <li>– Цаг уурын нөлөөллийн судалгаа хийх</li> <li>– Ул хөрсний тогтоц ба ангиллын судалгаа хийх</li> <li>– Хөрсний физик, механик шинж чанарын судалгаа</li> <li>– Цооногуудын бичиглэл болон стандарт пенетрацийн туршилт хийх</li> <li>– Проктор туршилт хийх</li> <li>– Калифорнийн даацын хувь /CBR/-ийг тодорхойлох,</li> <li>– Цооногийн инженер-геологийн зүсэлтийг хийх ба үеийн зузаан шинж чанарыг тодорхойлох</li> <li>– Цооногуудын байршлын зураглал гаргах, солбицол /WGS-84/-оор харуулах</li> </ul> </li> <li>2. Хиймэл хучилтын техникийн үзүүлэлтийг тодорхойлох</li> </ol>

	<ul style="list-style-type: none"> <li>– Хиймэл хучилтаас сорьцыг зориулалтын багажаар авч, зузааныг тодорхойлох</li> <li>– Сорьцод хийгдэх туршилт шинжилгээг Монгол улсын итгэмжлэгдсэн лабораториор хийлгэх</li> <li>– Сорьцын нягт ба нягтралыг тодорхойлох,</li> <li>– Сорьцын бат бэхийн туршилтыг хийх ба дүүргэгчийн ширхэглэлийг тодорхойлох</li> </ul> <p>3. Геотехникийн судалгааны тайлан гаргах</p> <ul style="list-style-type: none"> <li>– Хөрсний инженер геологийн судалгаа, хиймэл хучилтын техникийн үзүүлэлтийг тодорхойлох дээжийг хөөрч буух зурвас, явгалах зам, агаарын хөлгийн зогсоолын гадаргууд 8-аас багагүй байршилд хийх</li> <li>– Хийгдсэн судалгааны ажил болон холбогдох туршилт, шинжилгээг үндэслэн геотехникийн судалгааны тайлан боловсруулах</li> <li>– Геотехникийн судалгааны ажилтай шууд холбогдолгүй, хэт өргөн цар хүрээний, хуучирсан мэдээллийг тайланд оруулахаас зайлсхийх</li> </ul> <p>4. Тайлан нь Монгол улсын норм, дүрэм, стандартууд болон холбогдох бусад хууль, журам, аргачлалын шаардлагыг хангасан байх</p> <p>5. Геотехникийн судалгааны тайланд төсөл хэрэгжүүлэгчээс албан ёсоор санал авсан байх</p> <p>6. Тайлан, холбогдох баримт бичгүүдийг эрх бүхий албан тушаалтнаар баталгаажуулан эцсийн байдлаар хүлээлгэн өгөх</p> <p>7. Судалгааны үед цуглуулсан фото зураг, бичлэгүүдийг захиалагч талд хүлээлгэн өгөх</p>
Ажил гүйцэтгэх хугацаа	Хугацаа Ажил гүйцэтгэх гэрээ зурагдсанаас хойш 4 сар байна.
Материалын бүрдэл	Ажлын тайлан хүлээн авах <ul style="list-style-type: none"> <li>• Тайланг Иргэний нисэхийн ерөнхий газарт хэвлэмэл болон файл хэлбэрээр тус бүр 3 хувь ирүүлнэ.з</li> </ul>